



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Энхтөмөртэй 2019 онд 1 жилийн хугацаатай контракт байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Б. ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА


Д. АРИУНБОЛД